

АМЕРИКИЙН АШИГ СОНИРХОЛ МОНГОЛД БИЙ

*Л.Бэгзжав**

Монгол Улс-АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосоны 15 жилийн ойд зориулж тус хүрээлэнгээс эрхлэн АНУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд ноён Жон Дингертэй нөхөрсөг уулзалт хийв. Уулзалтад УИХ-ын гишүүн, Монгол-Америкийн Парламентийн бүлгийн дарга, ШУА-ийн ерөнхийлөгч, академич Б.Чадрраа, Монголын АНУ судлалын төвийн ерөнхийлөгч, академич Ч.Далай, ГХЯ-ны Ази, Америкийн газрын орлогч дарга, доктор Ж.Гөлгөө нарын албаны хүмүүс болон Олон улс судлалын хүрээлэн, Америк судлалын төвийн эрдэмтэн, судлаачид оролцлоо.

Нөхөрсөг уулзалтан дээр ноён Элчин сайд Ж.Дингер “Ж.Бушийн гадаад бодлого, АНУ-Монголын харилцааны өнөөгийн байдал, төлөв” сэдвээр лекц уншиж, эрдэмтдийн сонирхсон асуултанд хариулт өглөө.

Ноён Элчин сайд Монгол-Америкийн хооронд дипломат харилцаа тогтоосоны 15 жилийн ой болж байгаатай холбогдуулан Монголд ирээд нэг жил ажиллахад төрсөн сэтгэгдэл, Монголын талаар ямар ойлголттой болсон; АНУ-ын хувьд Монгол алс холын орон боловч ямар учраас АНУ улс Монгол Улсад анхаарлаа хандуулж, үйл ажиллагаагаа явуулж байгаа; Монгол-Америкийн харилцааны ирээдүйн талаар АНУ ямар байр суурьтай байгаа гэсэн гурван асуудлаар үзэл бодлоо илэрхийллээ. Элчин сайд Ж.Дингер ярихдаа:

- Монголд олон хууль тогтоомж гарсан ч тэр бүр олон түмний санаа бодлыг тусгасан эсэх, амьдралд хэрэгжиж байгаа эсэх нь эргэлзээтэй асуудал юм.
- Хэвлэл, мэдээллийн үүрэг ролийг дээшлүүлэх, хэвлэл мэдээллийнхэн мэргэжлийн чиг баримжаагаа сайтар баримтлах хэрэгтэй
- Монголд хүчтэй сөрөг улс төрийн хүчин сул байна. Нийгмийн амьдралд нөлөөлөхүйц тийм улс төрийн сөрөг хүчин байх ёстой.
- Монголын эдийн засгийн 75 хувийг эзлэж буй хувийн хэвшлийнхэнийг Засгийн газраас дорвитой дэмжих, бизнесийн хүрээнийхэнтэй ойр ажиллах хэрэгтэй,

* Л.Бэгзжав - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор, Олон улс судлал” сэтгүүлийн ерөнхий менежер

- Авилгалын асуудал Монголд газар авч, Монголыг зовоож буй нэг асуудал болоод байгааг тэмдэглэн хэлэв.

Тэрээр цааш нь Америкийн Монгол дахь сонирхол бол шилжилтийн үед Монголд дэмжлэг тусламж үзүүлэх явдал юм. Ингэснээр Монголын улс төрийн тогтвортой байдалд төдийгүй бүс нутгийн тогтвортой байдалд нөлөө үзүүлнэ. АНУ Монголд тусалснаар Монголын зах зээл нэмэгдэнэ, Америкийн хөрөнгө оруулалт ч нэмэгдэнэ. Монгол Улс хөгжвөл Зүүн хойт Азийн бүс нутагт эзлэх байр суурь нэмэгдэж, энэ хэрээр энэ бүс нутаг дахь АНУ-ын үйл ажиллагаанд түлхэц болно гээд АНУ ардчилалын үнэ цэнийг мэддэг, энэ талаар Монгол Улс амжилт олно гэдэгт итгэдэгээ илэрхийлэв.

Элчин сайд Ж.Дингер хэлэхдээ: Монголд бидний сонирхол бий. АНУ-ын сонирхол байгаа учраас бид Монголд байгаа болохоос Монголчууд сайхан зантайд нь байгаа юм бишээ. Бид Америк-Монголын сонирхолд нийцэхүйц эдийн засгийн хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлж байна.

Монголын талаархи АНУ-ын байр суурь гэвэл Америкчууд Монголыг хөгжинө гэдэгт итгэдэг. Гол нь хувийн сектор хөгжинө гэдэгт итгэж байна. Хувийн секторийнхэнийг чөлөөтэй байлгаж, тэдний үйл ажиллагааг идэвхжүүлээсэй гэж бид үздэг. Монголд одоо ямар нэгэн сургалт, семинар зохиох шаардлагагүй гэж үзэж байна. Ийм ажил хангалттай зохиогдсон. Гагц үйл ажиллагаа нь бага байна. Би Монголд нэг жил болохдоо ажил амьдралын 25 жилдээ үзээгүй олон семинар хийхийг үзлээ. Одоо үйл ажиллагаагаараа, ажил хийж харуулах л үлдэж байна. Өнгөрсөн жил донор орнууд Монголд 300 сая долларын тусламж үзүүлэхээ амалсан. Одоо зөвхөн ажлаа эхлэх асуудал үлдэж байна. Одоо хийхгүй бол хэзээ хийх вэ? Бид хийхгүй бол хэн хийх вэ гэдэг асуудал тулгарч байна гэдгийг цохон тэмдэглэв.

Эцэст нь ноён Элчин сайд Ж.Дингер тэмдэглэхдээ: Монголын ардчилал, зах зээлийн сонгосон замыг АНУ дэмжиж байна. АНУ-ын анхдагч, гол, чухал зорилго бол Монголыг дэмжих явдал юм. Бид Монгол Улс амжилт олбол АНУ амжилт олно гэсэн байр суурь баримталж байна.

АНУ-Монгол Улс хоёр бие биенээ мэддэг болоод богинохон 15 жил болсон ч андууд болж амжсан. Монголд хөгжлийн саруул сайхан ирээдүй байна гэж АНУ үздэг гэдгээ дахин илэрхийллээ.